

**Е.А.Торчинов: Орос орон дахь буддын  
философийн түүхэн тойм (лекцийн хураангуй)**

**Магсаржавын Гантуяа \***

*Доктор (Sc.D), профессор  
Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн  
Улаанбаатар, Монгол Улс  
gantuyam@yahoo.com*

**Хураангуй**

Евгений Алексеевич Торчинов (1956-2003) нь орчин үеийн Оросын алдарт шашин судлаач, Буддын судлаач, түүхч, философийн ухааны доктор, эрдэмтэн профессор бөгөөд одоогийн Санкт-Петербургийн Их сургуулийн Дорно дахины факультетад суралцаж төгсөөд тэндээ 10 гаруй жил, мөн Оросын шашны түүхийн музейд ажиллаж, “Религиоведение” эрдэм шинжилгээний нэрт сэтгүүлийн редактораар ажиллаж байжээ. Энэ удаад түүний бичсэн Орос орон дахь буддын философийн талаар бичсэн лекцийн хураангуйг уншигч олны хүртээл болгон ийнхүү орос хэлнээс орчуулан нийтэлж байна.

**Түлхүүр үгс:** *Орос, буддын философи, түүх, шашин судлал*

**A historical overview of Buddhist philosophy in Russia  
(summary of lecture)**

**Gantuya Magsarjav\***

*Doctor (Sc.D), professor  
Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences  
gantuyam@yahoo.com*

**Abstract:**

Evgeny Alekseevich Torchinov (1956-2003) was a well-known contemporary Russian religious scholar, Buddhist scholar, historian, Doctor of Philosophy, Professor of Science, and served as editor of the well-known scholarly journal Religious Studies. This time the summary of his lecture on Buddhist philosophy in Russia is translated from Russian and published for readers.

**Keywords:** *Russia, Buddhism religious studies and history*

---

\*Орч М.Гантуяа



© The Author(s) 2023

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

<https://orcid.org/0000-0003-0414-8494>

Received: 29 August 2023

Accepted: 05 October 2023

## I. Оршил

Евгений Алексеевич Торчинов (1956-2003) нь орчин үеийн Оросын алдарт шашин судлаач, Буддын судлаач, түүхч, философийн ухааны доктор, эрдэмтэн профессор бөгөөд одоогийн Санкт-Петербургийн Их сургуулийн Дорно дахины факультетад суралцаж төгсөөд тэндээ 10 гаруй жил, мөн Оросын шашны түүхийн музейд ажиллаж, “Религиоведение” эрдэм шинжилгээний нэрт сэтгүүлийн редактор байсан. 1993 онд “Буддын гэгээ” олон улсын нийгэмлэгийг байгуулахад оролцож, ерөнхийлөгчөөр нь ажиллаж байсан ба Даогийн шашны түүхийн асуудлаар докторын зэрэг хамгаалжээ. 1998 оноос Санкт-Петербургийн их сургуулийн Философийн факультетын Шашны философи, шашин судлалын тэнхимийн эрхлэгчээр ажиллаж, Хятадын шашны талаар гадаад дотоодод лекц уншиж байв. 20 орчим ном бичиж, олон тооны эх сурвалжийг хятад хэлнээс орчуулан, өгүүллэг нийтлэл хэвлүүлсэн. Гол бүтээл нь «Буддын судлалын оршил» хэмээх лекцийн эмхэтгэл болой.

## II. Судалгааны арга зүй

Буддизмыг шинжлэх ухааны үүднээс судлах үйл хэрэг Европт XIX зууны эхэн үеэс эхэлсэн. Энэ зуунд Буддын судлалын гол чиглэлүүд аажмаар бүрэлдэн тогтож эхэлсэн бөгөөд тэдгээр нь XX зууны Европын Буддын судлалд чухал суурь үүрэг гүйцэтгэсэн юм. Эдгээр чиглэл нь: Франц-Бельгийн чиглэл, Англо-Германы чиглэл, Оросын (Петербург) чиглэл - эдгээр юм. XX зуунд Буддын судлалын бараг бүх гол асуудлаар тэргүүлэгч болсон Америк, Японы чиглэлүүд дээрх судалгааг нөхөн гүйцээж байна (Е.А.Торчинов, Введение в буддологию. Курс лекций. 2000).

XX зууны дунд үе хүртэл Англо-Германы чиглэл нь хожуу үеийн Их хөлгөний урсгалыг уламжлалт бус хэмээн үзэж Тхеравада болон пали хэлт сурвалжид голлон анхаарлаа хандуулсан гэж түүхэн ретроспектив үүднээс хэлж болно. Франц-Бельгийн чиглэл ерөнхийдөө Энэтхэгийн Буддизмын түүх, түүний гүн ухааныг сонирхон авч үзэж байсан ч, католик шашны тодорхой утга агуулга бүхий нэлээд тодорхой евро-төвт парадигмын хүрээнд хязгаарлагдаж байв. Оросын (ялангуяа О.О.Розенбергийн үеэс хойших) чиглэлийн талаар сүүлд арай дэлгэрэнгүй ярих болно.

XIX зууны 20-30-аад оны үед Санкт-Петербургийн ШУА-ийн гишүүн, Германы эрдэмтэн Я.И.Шмидт (1779-1847) Буддын шашны талаарх хэд хэдэн судалгаа (герман хэл дээр), мөн орос хэл дээр анхны түвэд хэлзүйн дүрмийг хэвлүүлснээр Орос дахь Буддын судлалыг эхлүүлсэн юм. Монгол, түвэд хэлээрх эх сурвалжийн судалгаандаа үндэслэн бичсэн түүний бүтээлүүд Европт шуугиан дэгдээж, А.Шопенгауэр хүртэл “Ертөнц бол дур хүсэл ба төсөөлөл мөн” хэмээх гол бүтээлийнхээ нэгдүгээр ботийн төгсгөлд билиг барамидын тухай өгүүллээс нь эш татсан байдаг.

Гэхдээ Орос дахь Буддизмыг цэвэр шинжлэх ухааны үүднээс авч үзсэн судалгааг Паллади Кафаров (1817-1878), академич В.П.Васильев (1818-1900) нар эхлүүлсэн. Паллади (Петр Иванович) Кафаров олон жилийн турш Бээжин дэх Оросын Шашны тэргүүн байсан ч шашнаас илүү шинжлэх ухаанд зүтгэж байжээ. Тэрээр шашныг цэвэр шинжлэх ухааны үүднээс тайлбарлаж байсан бөгөөд түүний

судалгаанд Буддын шашны түүх маш чухал байр суурийг эзэлж байв. Харамсалтай нь түүний олон бүтээл өнөөг хүртэл хэвлэгдээгүй л байна.

В.П.Васильев бол Хятадын уран зохиолын түүх, Дао болон Күнзийн шашин судлал, шашныг янз бүрийн шинжлэх ухааны үүднээс тайлбарласан олон чухал бүтээл туурвисан хэдий ч жинхэнэ академич, ялангуяа Буддын судлаач байсан юм. Санскрит, хятад, түвэд хэлээс гадна мөн манж, монгол болон дорно дахины бусад хэл мэддэг байсан тул В.П.Васильев нэлээд өргөн хүрээний эх сурвалж дээр судалгаагаа явуулж байв. Түүний нэр тухайн үедээ л Европт алдаршсан. Гол бүтээл “Буддын шашин: домог, түүх, утга зохиол” (1857-1869) номыг нь хэвлэгдэнгүүт л герман хэл рүү орчуулжээ. Эрдэмтэн В.П.Васильевын бүтээлүүд дэх арга зүйн үндсэн дутагдал нь (түүхэн талаас ойлгож болох ч) илэрхий европ-төвт үзэл байсан бөгөөд заримдаа тэрээр судалж буй соёлдоо үл тоомсорлосон хандлага үзүүлсэн байдаг.

Орос улсад Энэтхэг судлалыг үндэслэгч нь И.П.Минаев (1840-1890) байв. Өмнө нь тэрээр хятад, түвэд эх сурвалж ашиглан Орос дахь Буддын судлалд хүчин зүтгэж байсан бөгөөд Хятад бол Оросын хөрш орон, мөн Оросын эзэнт гүрний харьяат буриад, халимагууд (Тува 1914 онд л Оросын талд орсон) нь Түвэдийн Буддизмыг шүтдэг байсныг тооцвол энэ нь ойлгомжтой зүйл. И.П.Минаев пали хэл дээрх эх сурвалжийг голчлон судалдаг байсан ч, Винайн судрыг судлахад онцгой анхаарал хандуулж байв (тэрээр Винайн хамгийн үндсэн эх сурвалж болох Пратимокша судрыг орос хэл рүү орчуулсан). Түүнээс л академич Ф.И.Щербатской Оросын Буддын сонгодог судалгааныхаа эхийг авсан юм..

Энэ мэт Буддын алдартай онолын судалгаанаас гадна хээрийн ажиглалт судалгаа, угсаатны зүйн судалгааг голлон эрхэлж байсан эрдэмтдийг дурдахгүй өнгөрч болохгүй. Тэд бидэнд тухайн үеийн Буриад, Монгол, зарим талаар Түвэдийн лам хуврагуудын ахуй амьдрал, шашны зан үйлийн талаар үнэлж баршгүй мэдээлэл үлдээсэн билээ. Тэдний дотор юуны түрүүнд А.М.Позднеев, Г.Ц.Цыбиков, Б.Б.Барадин зэрэг эрдэмтэд орно.

### **III. Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг**

1897 онд С.Ф.Ольденбург (1863-1934) Оросын төдийгүй дэлхийн Буддын судлалын түүхэнд асар их үүрэг гүйцэтгэсэн Bibliotheca Buddhica (Буддын номын сан) цувралыг үүсгэн байгуулсан билээ. Тун удалгүй энэхүү цуврал нь олон улсын түвшинд асар их нэр хүндийг олсон бөгөөд өнөөг хүртэл нэр хүндээ алдаагүй гадаад орнуудад дахин дахин хэвлэгдсээр байгаа боловч 1930-аад оны сүүлчээс уг цувралууд гарахаа больсон (1960-1980-аад онд сэргээх оролдлого хийсэн ч үр дүнд хүрээгүй) юм. Цувралын үндсэн зорилго нь Буддын сонгодог (гол төлөв санскрит ба түвэд; цувралд Хятадын буддизмыг маш бага оруулсан) зохиолуудыг эрдэм шинжилгээний зориулалтаар судалгааны оршил, тайлбар, зүүлтийн хамт хэвлэн нийтлэх явдал байв. Цувралд (тийм олон биш ч) Буддын сурвалжуудыг орчуулан хэвлэж байсан. Буддын олон талт номын сан бий болсон нь Оросын Буддын судлалын хөгжлийн шинэ, “сонгодог” үеийг эхлүүлсэн бөгөөд энэ нь юун түрүүнд академич Ф.И. Щербатскойн (1869-1942) нэртэй холбоотой. Гэхдээ энэхүү эрдэмтэн болон түүний судалгааны урсгал чиглэлийн талаар ярихын өмнө

Оросын Дорно дахины судлалын тэнгэрт агшин зуурын солир мэт гялалзаад одсон өөр нэгэн агуу Буддын судлаачийн тухай ярих хэрэгтэй. Энэ бол О.О.Розенберг (1888-1919) билээ.

О.О.Розенбергийг Ф.И.Щербатскойн шавь гэх нь олон боловч үнэндээ яг ч тийм биш байв. Щербатскойн шавь гэгдэж байсан Розенберг нь тусдаа бие даасан судалгаа явуулж байсан бөгөөд түүний дүгнэлт, хандлага нь их академичийн дүгнэлт, арга зүйн зарчмуудаас эрс ялгаатай байв. Розенберг нь үнэндээ нэг л ном бичсэн бөгөөд энэ номын зохиогч гэдгээрээ алдаршжээ. Энэ бол түүний “Буддын гүн ухааны асуудлууд” хэмээх магистрын ажил юм. Зохиогч Японд дадлага хийснийхээ дараа үүнийг бичсэн ба 1918 оны хувьсгалт үймээн самууны жил Петроградд хэвлэгджээ. Үнэндээ энэхүү “Буддын гүн ухааны асуудлууд” нь “Хятад, япон хэлт сурвалжид тулгуурласан Буддын судлалын оршил” хэмээх цор ганц бүтээлийнх нь хоёрдугаар хэсэг байв. Розенберг мөн Хятад, Японы буддизмын урсгал чиглэлүүдийг судлахад зориулсан гурав дахь хэсгийг бичихээр төлөвлөж байсан боловч түүнд үүнийг бичих хувь тавилан оногдсонгүй. Розенберг ихэвчлэн хятад, япон хэлээрх эх сурвалж дээр ажилласнаараа бараг зөвхөн Энэтхэг, Түвэд эх сурвалжаар судалгаагаа хязгаарладаг байсан Щербатской болон “түүнийг дагалдагсдаас” холджээ.

О.О.Розенберг үнэндээ Буддын судлалд хувьсгал хийсэн хүн. Энэ нь юу байсан бэ гэвэл:

1. Розенберг Буддизмд хэд хэдэн түвшин байгааг илрүүлж, нийтэд түгээмэл, ардын Буддизмыг философийн Буддизмаас зарчмын хувьд ялгаатай болохыг нь тогтоосон.
2. Тэрээр Буддын сургаалыг зөвхөн судраар төдийгүй системчлэгдсэн философийн тайлбар шастируудаар судлахын чухал болохыг харуулж, чухам шастируудын агуулгаар систем муутай бичигдсэн судрууд дахь Буддизмын философийн түвшинд ойлгож болно хэмээсэн.
3. О.О.Розенберг анх удаа Абхидхарма бол Буддын философийн үндэс хэмээн тогтоож, Абхидхармад авч үздэг гол асуудал нь дхармын онол мөн хэмээн үзээд, түүнийг олон талаас нарийвчлан судалжээ.
4. Эцэст нь чухамдаа О.О.Розенберг “ерөнхий Буддизм” гэж байхгүй гээд, Буддизм бол түүхэн тодорхой урсгал чиглэл хэлбэрээр л оршин байсан гэдгийг үзүүлсэн юм.

Үүний зэрэгцээ дхармын онолын талаарх Розенбергийн тайлбар удаан хугацааны туршид ойлгоход нууцлаг мэт байв. Гол нь Оросын Буддын судлаач дхармыг эмпирик “оршихуй”-д агшин зуур гялбан өнгөрөх мэт илэрч байдаг ямар нэгэн трансцендент, үл ойлгогдох чинад зүйл гэж үзсэн юм. Үүний зэрэгцээ, сонгодог Абхидхармын сурвалжууд, түүний дотор Розенбергийн судалсан Васубандхугийн Абхидхармакошад ийм тайлбар өгөх ямар ч үндэслэл байхгүй, учир нь эдгээр сурвалж дахь дхарма нь үндсэндээ психофизик шинжтэй нэлээд “имманент” (сүнслэг, сэтгэллэг) төлөв юм. Розенберг хятад, япон хэлт, ялангуяа сэтгэл төдийтний Хоссо-шу (Хятадын фа сяан зонг) урсгалын эх сурвалж дээр ажилласан гэдгийг нь харгалзаж үзвэл түүнийг ойлгож болох юм. Нөгөө талаар,

Алс Дорнодод Фа-цан ба Сюань Зан нар хоорондоо мэтгэлцэж эхэлсэн үеэс л дхармын мөн чанар (фа син; дхармата) ба энэхүү мөн чанарын илрэл болох үзэгдэл (фа шян; дхармалакшана) хоёрыг ялгаж салгах болжээ. Эхнийхийг “трансцендент” зүйл, хоёр дахийг түүний эмпирик илрэл гэж Розенберг тайлбарласан аж.

Энэ үеэр мөн О.О.Розенберг (Ф.И.Щербатской, монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов болон бусад дорно дахины судлаачидтай хамтран) Буддын шашны анхны үзэсгэлэнг зохион байгуулахад оролцож, “Алс Дорнодын Буддын шашны ертөнцийг үзэх үзлийн тухай” хэмээх лекцээ толилуулав. Үүний дараа О.О.Розенберг учир битүүлгээр ор сураггүй алга болсон юм. Тэрээр Герман руу явах замдаа Таллин хотод саатаж, 1919 юм уу 1920 онд өвчнөөр нас барсан гэдэг нь илүү магадлалтай.

О.О.Розенбергийн шинжлэх ухаанд оруулсан гавьяа зүтгэл агуу боловч. Оросын Буддын судлалын чиглэлийг тэр биш, харин түүний эртний хамтран зүтгэгч, зарим талаар багш нь болох академич Ф.И.Щербатской (1866-1942) үндэслэсэн билээ. Щербатской Санкт-Петербург, Венийн их сургуульд маш сайн санскрит хэлний боловсрол эзэмшсэн. Венад тэрээр Европын хамгийн том санскрит судлаач Г.Бюлертэй хамт дадлага хийж байсан бөгөөд хожим түүний сурах бичгийг (Стокгольм, 1923) орос хэл рүү орчуулсан ба тэрхүү сурах бичгээр Оросын дорно дахины их дээд сургуулийн бүх Энэтхэг судлалын оюутнууд одоо ч суралцаар байна (1999 онд Санкт-Петербургийн “Лань” хэвлэлийн газар дахин хэвлэсэн). 1893 онд Щербатской Орост буцаж ирсэн боловч эхэндээ тэрээр шинжлэх ухааны чиглэлээр бус, харин нийгмийн үйл ажиллагаа эрхэлдэг (газрын албаны болон дүүргийн дарга) байсан юм. Зөвхөн 1899 онд л тэрээр шинжлэх ухаандаа эргэн ирж, Германы Буддын судлаач эрдэмтэн Якобитэй хамтран Бонн хотод ажиллах болжээ. 1900 онд тэрээр Санкт-Петербургийн их сургуулийн Дорно дахины факультетын Санскрит судлалын тэнхимийн дэд профессор болж, улмаар үлдсэн амьдралынхаа туршид их сургуулийн багшаар ажилласан юм. 1918 онд тэрээр Оросын ШУА-ийн жинхэнэ гишүүн болжээ. 1928 онд Ф.И.Щербатской ЗХУ-ын ШУА-ийн Буддын соёлын хүрээлэнгийн (ИНБУК) захирал болсон бөгөөд харамсалтай нь ердөө хоёр жил ажиллажээ. 1930 онд дөнгөж байгуулагдаад байсан Дорно дахины судлалын хүрээлэнг татан буулгасан бөгөөд Ф.И.Щербатской Энэтхэг-Түвэдийг хариуцсан засгийн газрын тэргүүн болжээ. Щербатскойн амьдралын сүүлийн жилүүд маш хүнд хэцүү өнгөрсөн. Түүний ихэнх шавь нар болон хамтран зүтгэгчдийг үл ялих хэргээр хэлмэгдүүлэн цаазлав. Түүний хамгийн алдартай шавь Э.Э.Обермиллер халдварт склерозоор нас баржээ. Академич өөрөө реакционизмыг номлодог идеалист шинэ-кантч үзэл болон “Энэтхэг хуврагийн” реакционизмыг хатуу баримтлах болсон тул жинхэнэ хавчлагад өртөж байв. Түүний бүтээлүүд Орост боловч зөвхөн англи хэлээр хэвлэгдэж байв. Дайн эхэлсний дараа Щербатской бусад академичдын хамт Боровой (Казахстан)-д цөлөгдөж, 1942 оны 3-р сарын 18-нд нас баржээ. Түүнтэй хамт Оросын сонгодог Буддын судлал мөхсөн бөгөөд Сталины хэлмэгдүүлэлтийн энэхүү дайралтаас хойш дахин сэргэж чадаагүй юм.

Ф.И.Щербатскойн хамгийн алдартай бүтээлүүд нь хэмээвээс: “Хожуу үеийн Буддын танин мэдэхүй, логикийн онол” (Теория познания и логика по учению позднейших буддистов. т 1-2. Санкт-Петербург, 1903-1909), “Буддын сургаалын

гол ойлголт ба Дхарма хэмээх үгийн утга” (The Central Conception of Buddhism and the Meaning of the Word Dharma, Центральная концепция буддизма и значение слова “дхарма”. Лондон, 1923 г.), “Нирваны тухай Буддын үзэл баримтлал” (The Conception of Buddhist Nirvana, Концепция буддийской нирваны. Ленинград, 1927 г.), “Буддын логик” (The Buddhist Logic, Буддийская логика, т. 1-2. Ленинград, 1930-1932 г.) зэрэг нэгэн сэдэвт бүтээлүүд юм. Нэмж хэлэхэд, Щербатской бол «Bibliotheca Buddhica» цувралд олон тооны өгүүлэл, Буддын жижгэвтэр эх сурвалжуудын орчуулгыг нийтлүүлсэн судлаач билээ.

Дээр нэр дурдсан зохиолуудын эхнийх ба гурав дахь нь сэтгэл төдийтний (Дхармакирти, Дхармоттара нарын) логик-эпистемологийн сургаалыг, хоёр дахь нь төв үзлийн гүн ухаан ба нирваан хэмээх ойлголтын тухай төв үзэлтнүүдийн тайлбарыг судлахад зориулагдсан болно.

Эндээс харахад Щербатской болон түүний чиглэлийнхэн Буддын гүн ухааныг ихэвчлэн хамгийн боловсронгуй хэлбэрээр авч үзсэн байх бөгөөд зарим тохиолдолд уламжлалт гүн ухаанд хэтэрхий ач холбогдол өгч шашны сургаал болон йогийн бясалгалаас нь ангид судалсан нь харагдана. Ф.И.Щербатской Буддын гүн ухааныг тайлбарлахдаа А.Введенский (Ф.И.Щербатскойн нэгэн багш), И.Лапшин зэрэг сэтгэгчдийн баримталж байсан шинэ-кантч философийн нэр томьёо, арга хэрэгслийг ашигласан (О.О.Розенберг ч мөн Лапшинтай гүн ухааны асуудлаар зөвлөлдөж байсан нь сонирхолтой) байдаг. Үүний зэрэгцээ Ф.И.Щербатской уламжлалт хэлзүйн орчуулгаас татгалзаж, Буддын сонгодог сурвалжийг философийн хангалттай үндэслэлээр орчуулах хэрэгтэй гэж үзээд, Буддын гүн ухааны зохиолыг орчуулахад цоо шинэ хандлагыг дэвшүүлсэн юм. Хэл шинжээчид биш, харин философичид Буддын сэтгэлгээг судлах ёстой гэж академич үзэж байв. Щербатскойн чиглэлийнхний өөр нэгэн чухал арга зүйн баримтлал нь Буддын сэтгэлгээний хөгжлийн үеүдийг түүхэн тодорхой үйл явдлаас гадуур ойлгох боломжгүй тул Буддын гүн ухааны түүхийг гадаад тогтсон таалалтууд, ялангуяа Брахманизмын гүн ухааны сургуулиудтай хийсэн мэтгэлцээн дунд авч үзэх шаардлагатай гэж үзсэн явдал юм.

Мэдээжийн хэрэг, юун түрүүнд Ф.И.Щербатской бол хожуу үеийн сэтгэл төдийтний логик, эпистемологийг судалсан эрдэмтэн гэдгээрээ алдартай. Түүний бүтээлүүдийн ачаар Дигнага, Дхармакирти, Дхармоттара нарын нэрс дэлхийн эрдэмтдэд танигдсан нь тэдний өвийг судлах цаашдын ажилд түлхэц болсон юм. Өмнө дурдсанчлан, сэтгэл төдийтний философийг Ф.И.Щербатской кантч нэр томьёогоор тайлбарласан нь зарим талаар эргэлзээ төрүүлдэг. Үнэн хэрэгтээ Щербатскойн тодорхойлсон хэллэг, түүний герменевтик загвар нь Энэтхэг сурвалжийн орос хэл дээрх орчуулгыг гүн ухаан талаасаа нэлээд сонсогдох боломжтой болгосон. Гэхдээ орчуулагч юун түрүүнд Энэтхэгийн гүн ухааныг Европын сэтгэгчдэд аль болох нийтлэг талаас нь илэрхийлж чадсан ч, Буддын эх сурвалж дахь европчуудын хувьд цоо шинэ, өвөрмөц соёлын агуулга нь ихэвчлэн далдлагдсан байв. Энэ нь зарим талаараа үл ойлголцол, Буддын сэтгэлгээг дур мэдэн европчилоход хүргэсэн юм. Үүний хамгийн тод жишээ бол Ф.И.Щербатской сэтгэл төдийтний маш чухал нэр томьёо болох свалакшана (өөрийн шинж чанар, өөрийн мөн чанар)-г “өөртөө байгаа юм” (вещь в себе) гэж орчуулсан нь энэхүү

нэрийн агуулгыг ойлгоход тусалсан гэхээсээ илүү төөрөгдүүлжээ. Гэхдээ бүхэлдээ Щербатскойн энэ чиглэлийн судалгаа нь Европын Буддын судлалд анхдагч бөгөөд түлхэх хүч, урам зориг оруулсан ажил болсон юм. Буддын гүн ухаан дахь “дхарма” хэмээх ойлголтын утгыг судалсан түүний судалгааны талаар ч дээрхтэй адил зүйл хэлж болно. Хэдийгээр Ф.И.Щербатскойн судалгаа О.О.Розенбергийн бүтээлтэй адил хурц тод гялалзаагүй ч, тэрээр Розенбергийн алдааг амжилттай зассан билээ. Тэрээр дхармуудыг трансцендент ба эмпирик илрэл хэмээн Розенбергийн ангилсныг зөв зүйтэй няцааж, Энэтхэгийн Абхидхарма сурвалжийн агуулгын судлал руу эргэж хандсан юм.

Ф.И.Щербатской дхармын тухай судалгаагаа Бага хөлгөний эх сурвалжид тулгуурлан явуулсан, харин нирвааны тухай судалгаагаа Их хөлгөний, тэр тусмаа хоосон чанарыг номлосон эх сурвалжид тулгуурлан явуулсан боловч академич өөрөө “Нирвааны тухай Буддын үзэл баримтлал” номоо дхармын тухай судалгааныхаа үргэлжлэл гэж үзсэн явдал нь хамгийн их маргаан дагуулсан юм. Энэ бүтээлээ Ф.И. Щербатской нь Франц-Бельгийн Буддын судлалыг ахалж байсан Луис де ла Валле-Пуссины дэвшүүлсэн нирвааны талаарх үзэл баримтлалд эсрэгцүүлэн бичсэн гэдэг. Бельгийн эрдэмтэн эртний Буддизм буюу “Буддагийн үеийн Буддизм”-ыг Буддын тайлбар шастируудал сөргөлдүүлэн, эхнийхийг йогийн бясалгалтай холбоотой гэж үзээд йогийг ид шид, гоц гайхамшиг мэтээр ойлгож байв. Харамсалтай нь йогийг ийнхүү ойлгох нь католик шашны европ-төвт үзлийн үр дагавар байсан ч, энэ нь энэхүү агуу эрдэмтний судалгааны онцлог тал болсон юм.

Луис де ла Валле-Пуссиний йогийн талаарх ойлголтыг Ф.И.Щербатской зөв зүйтэй бөгөөд хатуу чанга шүүмжилж, Буддын шашинтнууд болон Йогийн судрын зохиогч Патанжал нарын байр суурь гайхалтай давхцаж байгааг үнэн зөвөөр онцлон тэмдэглэсэн ч, Буддын уламжлалт гүн ухааныг йогийн бясалгалаас нь эрс салгаж хэтрүүлэн үнэлсэн талтай.

Гэсэн хэдий ч Щербатскойн явуулсан судалгааны хамгийн чухал зүйл бол тэрээр төв үзэл, ялангуяа Нагаржунагийн сургаалыг тайлбарласан явдал болно. Ф.И.Щербатской нэг талаас, шуныята бол хоосон зүйл биш, харин харьцангуйн онол гэж үзсэн, нөгөө талаас, төв үзэлтнүүд Буддагийн Үнэмлэхүй дээд чанарт итгэдэг хэмээснээрээ төв үзлийг “харьцангуй” ба “үнэмлэхүй” аль аль талаас тайлбарласан анхны хүн билээ. Чингэхдээ Щербатской Спинозагийн “Deus sive natura” болон “Deus sive substantia” хэмээх томъёоллыг дурдсан байдаг. Щербатскойн хувьд шуныята бол учир шалтгааны нөхцөлт байдлаараа сансар оршихуйн харьцангуй байдал мөн бөгөөд үүний зэрэгцээ энэхүү нөхцлийн нөгөө талд үнэхээр оршин буй нэгдмэл байдал болох Үнэмлэхүй бодитой оршино. Ф.И.Щербацкой бол зөвхөн эрдэмтэн судлаач төдийгүй Оросын (Санкт-Петербург, Ленинградын) Буддын судлалын анхны эрдэмтдийн бүхэл бүтэн үеийг хүмүүжүүлсэн гайхалтай сурган хүмүүжүүлэгч байсан юм. Ф.И.Щербатскойн шавь нарын дунд хамгийн алдартай нь эрдэмтэн Е.Е.Обермиллер байсан нь эргэлзээгүй.

Е.Е.Обермиллер (1901-1935) нь Ф.И.Щербатскойн сонгодог Буддын судлалын уламжлалт зарчмуудыг үргэлжлүүлсэн эрдэмтэн. Обермиллер Майдар-Асангагийн “Татхатагарбха онол”-ын үндэс Абхисамаяланкара, Ратнаготравибхага

сурвалжуудыг судлахад онцгой анхаарал хандуулсан. Обермиллер ихэнх бүтээлээ англи хэлээр хэвлүүлсэн. Харамсалтай нь Е.Е.Обермиллер хүнд өвчний улмаас 34-хөн настайдаа нас баржээ. Тэрээр амьдралынхаа сүүлийн жилүүдэд Буриадын эрдэмтэй лам нараас Буддын гүн ухаанд суралцжээ.

Академич Щербатской Буддын судлалын гайхалтай урсгал чиглэлийг бий болгосон ч, харамсалтай нь Сталины хэлмэгдүүлэлтийн улмаас судлаачдаасаа хагацаж уналтанд орсон билээ. 1942 онд Щербатскойг нас барсны дараа Орост (ЗХУ) Буддын судлал 15 жилийн турш ор тас үгүй болсон юм.

“Хрущевын гэсгээл” гэгч үе эхэлснээр Оросод Буддын судлал сулавтар сэргэсэн ч дайны өмнөх үеэсээ давж чадаагүй. Энэхүү сэргэлтийн үйл явцад Түвэд судлаач, Буддын судлалын нэрт эрдэмтэн, алдартай Буддист зураачийн хүү Ю.Н.Перих Энэтхэгээс Орос эх орондоо эргэн ирсэн явдал онцгой нөлөөлсөн юм. Ю.Н.Перих «Bibliotheca Buddhica»-г сэргээх талаар их зүйл хийж, 1960 онд эртний Буддын пали хэлт сурвалжийн нэг болох Дхаммападагийн орчуулгыг (В.Н.Топоров орчуулсан) өөрийн нэрийн далбаан дор хэвлүүлсэн билээ. Энэхүү орчуулгыг хэвлүүлсэн нь дуулиан тарьж, эрдэм шинжилгээний албаны хүмүүс эрдэмтнийг “хуврагийн номлол” түгээсэн гэж буруутгасан ба Ю.Н.Перих энэхүү хавчлагыг тэсэж ядан удалгүй нас баржээ. Гэсэн хэдий ч 1963 онд «Bibliotheca Buddhica»-ийн нэрээр дахин Б.И.Панкратов, Е.Н.Темкин нар Е.Е.Обермиллерийн хэвлүүлэхээр бэлтгэсэн Камалашилагийн “Пурва Бхавана Крама”-ийн нэгэн бүлгийг нийтлүүлсэн юм. Үүний дараа «Bibliotheca Buddhica» дахин хэдэн арван жилийн турш унтаа байдалд оров.

1960-1970-аад оны зааг дээр Оросын Буддын судлалын цэцэглэлтийн хоёр дахь үе эхэлсэн билээ. Энэ үе нь эхэн үеийнхээ тэр их хүчийг үзүүлээгүй ч, маш их зүйлийг хийхээр төлөвлөсөн байв. Үүнд Тартугийн Улсын Их Сургуулиас гаргасан “Дохионы системийн тухай бүтээлүүд”, “Дорно дахины судлалын бүтээлүүд” зэрэг хэвлэлүүд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Тэдгээрт А.М.Пятигорский (Буддын судлалын аргазүйн асуудлууд, Буддын сэтгэл судлал, ухамсрын феноменологи; Сэтгэл төдийтний гүн ухааны оршил болгож сэтгэл ухамсрын мөн чанарын тухай М.Мамардашвилитэй хийсэн ярилцлага нь Буддын судлал төдийгүй философийн ач холбогдолтой байв), О.Ф.Волкова (Энэтхэгийн сонгодог буддизм), Л.Е.Мялль (Билиг барамидын эх сурвалж), Б.Д.Дандарон (Очирт хөлгөн, Цогчен, Махамудрагийн уламжлал) болон бусад “Буддын судлалын сэргэн мандалт”-ыг дэмжсэн олон эрдэмтэд судалгааны бүтээлээ тогтмол хэвлүүлж байв.

Гэсэн хэдий ч энэхүү “сэргэн мандалт” маш богино хугацаанд үргэлжилсэн юм. 1972 онд зөвхөн Буддын судлаач төдийгүй Буддын, бүр цаашилбал тарнийн йогийн бясалгагч (Буриадад олон алдартай лам нарыг төрүүлсэн эртний удамтай) Б.Д.Дандарон (Сталины үед хоёр удаа хэлмэгдсэн) баривчлагджээ. Түүнийг шашны бүлэглэл үүсгэсэн хэргээр буруутгасан. Дандароны бүлэглэлтэй ойр дотно харилцаатай байсан хэмээн Буддын судлаач олон эрдэмтдийг шүүх гэрчээр дуудсан байдаг. Удалгүй шоронд нас барсан Дандароныг шүүх буруутгаж, зарим гэрчийн мэдүүлгийн эсрэг шийдвэр гаргажээ. Буддын судлалын хувьд “Дандароны хэрэг” нь үнэхээр эмгэнэлтэй үр дагуулсан, тухайлбал, эрх баригчдын нүдэнд энэ чиглэлийн судалгаа явуулдаг эрдэм шинжилгээний ажилтнууд их сэжигтэй, бараг л үймээн



самуун дэгдээх гэж байгаа мэт үзэгдэх болов. Буддын судлал төгсгөл болж, Буддын судлалд холбогдох ихэнх судалгааны сэдвүүд хаагдаж байв. А.М.Пятигорский Англи руу, А.Я.Сиркин Израиль руу цагаачлан гарч, О.Ф.Волков, Л.Е.Мялль (энэ жилүүдэд түүний дургүйцэл улам нэмэгдсэн бөгөөд, 1990-ээд оны эхээр түүнийг Эстонийн радикал үндсэрхэг үзэлтнүүд ба Орост дургүйчүүдийн хуаранд хүргэсэн бололтой) нар шинжлэх ухааны амьдралаас бүрмөсөн хөндийрсөн юм.

Гэсэн хэдий ч уугуул Буддын судлалын гэрэл анивчсаар л байв. Хэдийгээр Орост Буддын судлал нь сонгодог утгаараа бараг устаж үгүй болж байгаа ч түүх, нийгэм, (жишээлбэл, Буддизм ба төрийн байгууллагуудын хоорондын харилцааны асуудал, Дорнын улс орнууд, дундад зууны үеийн Хятадын Буддын шашны ардын уран зохиол, Төв ба Зүүн Азийн соёлд Буддизмын гүйцэтгэх үүрэг гэх мэт) хөгжиж ирэв.

Энд Москвагийн урлаг судлаач Е.В.Завадскаягийн “Өрнө ба Дорно” (М., 1972; 1977 онд “Орчин үеийн Өрнийн ертөнц дэх Дорнын соёл” нэрээр дахин хэвлэгдсэн) номыг онцлон тэмдэглэхийг хүсэж байна. Энэхүү жижгэвтэр номд ХХ зууны Өрнийн соёлд Чань (Зэн) буддизмын нөлөөллийн тухай өгүүлдэг. Энэ ном Буддизмын бодит ач холбогдлын тухай тийм их биш ч, соёл хоорондын харилцааны шинэ үйл явцын талаар олон нийтэд мэдээлэх, дорно дахины судлаач залуучуудад Буддизмыг судлах сонирхол төрүүлэхэд маш чухал бөгөөд эерэг үүрэг гүйцэтгэсэн.

1970-аад оны хоёрдугаар хагас, 1980-аад оны эхээр Буддын судлал ихсэв. Хэдийгээр тэдний түвшин дэлхийн жишгээр нэлээд даруухан хэвээр байсан ч Буддын судлал сэргэсэн нь маш их урам зориг өгсөн хэрэг. Энэ үеэс Орос, Японы буддизмын түүхийн чиглэлээр судалгаа хөгжиж, Оросын хувьд уламжлалт Буддын судлалын бүтээлийг Энэтхэг, Түвэд судлалд чиглүүлж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Буриадын залуу эрдэмтэд Н.В.Абаев, Л.Е.Янгутов, С.Ю.Лепехов, С.П.Нестеркин болон бусад судлаачид Чань болон Алс Дорнодын Буддизмын бусад чиглэлийг судлахад идэвхтэй оролцох болов.

Шинэ үеийн төлөөлөгчид шинжлэх ухааны үйл хэрэгт идэвх гаргаж, өөрсдийгөө 90-ээд оны Оросын Буддын судлалын нүүр царай гэж тодорхойлсноороо 80-аад оны Орос дахь Буддын судлалын төлөв байдлыг ойлгоход маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм. 80-аад оны төлөөлөл бол А.Н.Игнатович (Японы Буддизмын түүх, Тендай, Ничирэн сургуулиудыг судалдаг), Л.Н.Меньшиков (Дунхуан агуйгаас гарсан Буддын сурвалж; бьяньвэнь төрлийн зохиол судалдаг), В.Н.Андросов (Нагаржуна судлаач), В.Г.Лысенко (Пали хэлт Буддизмын эхэн үеийг судалдаг), А.В.Парибок (Пали хэлт Буддизм судалдаг), А.М.Кабанов (Зэн ба Японы сонгодог утга зохиол судалдаг), М.Е.Кравцова (Дундад зууны эхэн үеийн Хятад дахь Буддизм ба нийгэм судлаач), С.Д.Серебряный (Энэтхэгийн шашин, гүн ухааны утга зохиол; Их хөлгөний судар судалдаг), М.Э.Ермаков (Хятад дахь Буддын ном зүй; Хятадын ардын буддизм судалдаг) болон бусад олон эрдэмтдийг дурдаж болно.

1970-аад онд Буддын судлалд идэвхтэй ажиллаж байсан нэгэн эрдэмтэн В.И.Рудой-г онцлон дурдах хэрэгтэй. Тэрээр (1980-1990-ээд оны зааг үед) Оросын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэнгийн Санкт-Петербург дахь салбарт Буддын судлалын бүлгийг байгуулсан хүн. Энэ бүлэг бол Ф.И.Щербатскойгоос хойш анх удаа Оросын Буддын судлалын тов тодорхой арга зүйн зарчмуудыг

боловсруулсан чиглэл мөн. Энэ чиглэлийн хамгийн идэвхтэй, тууштай гишүүд хэмээвээс В.И.Рудой, Е.П.Островская, Т.В.Ермакова нар юм. Энэ бүлгийн судалсан гол бөгөөд цорын ганц сэдэв нь сонгодог Буддын Абхидхарма, тэгэхдээ Абхидхарма бүхлээрээ ч биш, харин Васубандхугийн “Абхидхармакоша” зохиол байв. Энэхүү сурвалжийг цогцоор нь судалсны үндсэн дээр В.И.Рудойн бүлэг Буддын судлалын талаар ерөнхий өргөн хүрээтэй дүгнэлтийг гаргасан юм. Энэхүү чиглэлийн эерэг талыг дараахь байдлаар хэлж болно: 1) Буддын судлалын сонгодог асуудлуудыг авч үзэж, Ф.И.Щербатскойн уламжлалыг сэргээсэн; 2) онол, арга зүйн судалгааны боловсронгуй суурьтай герменевтик үйл ажиллагаа явуулсан, 3) сурвалжийг хэл шинжлэл, түүхэн философийн өндөр түвшинд судалсан. Үүний зэрэгцээ Васубандхугийн сургаалыг хэт үнэлж, түүнийг Буддизмд ерөнхийд нь шүүмжлэлгүйгээр тохсон (зөвхөн Энэтхэгийн Буддизмыг төдийгүй), заримдаа Бага хөлгөний үеийн Васубандхугийн философийг зүгээр л “норматив буддизм” буюу “сонгодог буддизм” мэтээр үзсэн нь судалгааны үнэ цэнийг бууруулсан юм. Ерөнхийдөө В.И.Рудойн судалгааны бүлгийнхнийг “Абхидхармакошагийн бүлгийнхэн” гэж нэрлэж болно.

1990-ээд оны эхээр Санкт-Петербургийн Улсын Их Сургуулийн гүн ухааны факультетын дэргэд Буддын судлалын чиглэл аажмаар бий болсон (Е.А.Торчинов, К.Ю.Солонин болон хэд хэдэн залуу эрдэмтдээс бүрдсэн) юм. Санкт-Петербургийн Улсын Их Сургуулийн Философийн факультетын Дорно дахины философи, соёл судлалын тэнхимийн дэргэд үүссэн энэ чиглэл нь В.И.Рудойн судалгаанаас эхлэлтэй ч, түүний судалгаанаас сэдэв болон хэд хэдэн хандлагаараа ялгаатай. Нэгд, их сургуулийн Буддын судлаачид үндсэндээ хятад хэлт сурвалж дээр ажилладаг, хоёрдугаарт, Буддизмыг олон ургалч үзлийн уламжлалтай гэж үзэх хандлагатай бөгөөд ямар нэгэн тогтсон “сонгодог” буддизмыг эрж хайх оролдлогоос татгалздаг юм.

Оросын Буддын судлал Өрнийхний судалгаанаас нэлээд хол хоцорсон гэдэг ч, эцсийн эцэст гол зүйл бол Орост жинхэнэ шинжлэх ухаанч Буддын судлал дахин бий болсон билээ.

Өрнийн Буддын судлал хурдтай урагшилж байгаа ч, өрнийхнийг Оросын Буддын судлаачдаас ялгаатай “орон зай” болгон хуваах нь учир дутагдалтай. Өрнийн Буддын судлал анх үүссэн цагаасаа л Ф.И.Щербатской тэргүүтэй Оросын сонгодог Буддын судлалтай нягт уялдаа холбоотой хөгжсөн. Паллади Кафаров, В.П.Васильев, Ф.И.Щербатской нарыг өрнийн судлаачид судалгаандаа ямагт дурдаж санал бодлыг нь үнэлж ирсэн. Ф.И.Щербатской “Нирвааны тухай Буддын ойлголт” гэх мэт номдоо Луис де ла Валле-Пуссиний хандлагыг шүүмжилсэн бөгөөд энэ бүтээлийн тоймыг Британийн Буддын сонгодог судлаач С.А.Ф.Рис Дэвидс бичсэн буй. Зөвхөн XX зууны дунд үеэс л өрнийн ба Оросын Буддын судлалын хооронд “төмөр хөшиг” өлгөж, Оросын Буддын судлал уналтад орсныг өрнийхнөөс судалгаагаараа хоцорсон мэт тодорхойлох болсон юм.